

**Гадаад, дотоодын зээл, тусламжаар ХСҮТ-д хэрэгжүүлж буй
судалгааны ажил, төсөл, хөтөлбөрийн судалгаа**
(2025 оны байдлаар)

	Хугацаа	Төслийн нэр	Санхүүжилтийн эх үүсвэр	Төслийн хариуцагч
1.	2021-2024	“Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үндэсний сүлжээг байгуулах” төсөл	1. Австрийн Засгийн газар 2. Монгол улсын Засгийн газар (10'000'000 евро)	Э.Хишигдорж /ХСҮТ-ийн ҮАЭ дэд захирал/ Т.Ундармаа /ХСҮТ-ийн ХХБТЭА-ны дарга/
2.	2024-2025	Хавдар судлалын үндэсний төвийн хорт хавдрын эрт илрүүлэг, дурангийн оношилгоо, эмчилгээний төв төсөл	Улсын төсөв (8'680'168'680 төгрөг)	Д.Алтанням /ХСҮТ-ийн БМАБА-ны дарга/
3.	2025 он	“Бидний түүх-биднийг нэгтгэнэ: хүн төвтэй тусламж үйлчилгээ” хавдраас урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгааны ажлын төсөл	НҮБ-ын Хүүхдийн сан (37.6 сая төгрөг)	Л.Энхээ /ХСҮТ-ийн ҮДА-ны дарга/
4.	2013 оноос хойш	“Умайн хүзүүний хавдрын дотуур эмчилгээний гурван хэмжээст дүрслэлд суурилсан аргын үр дүнг судлах нь (АЦХАФ)-ын Умайн хүзүү-V олон төвт эмнэл зүйн судалгаа/”	Япон улсын засгийн газар (Төсгайлсан төсөвгүй)	Я.Эрдэнэтуяа /ХСҮТ-ийн Туяа ЭТ-ийн эмч/
5.	2023-2027	Архаг гепатитийн Д вирүстэй өвчтөнүүдийн дунд гепалатидын тарилгыг хийх олон төвт, санамсаргүй түүвэрлэлттэй, давхар нууцлалт, плацебо-хяналт бүхий II-а шатны эмнэл зүйн туршилт судалгаа (L47-HD-IIa)	БНХАУ-ын Shanghai HEP Pharmaceutical Co.,Ltd (20'500'000 төгрөг)	Ч.Мөнхзаяа /ХСҮТ-ийн ЭЦНБМЗТ-ийн эмч/
6.	2024-2029	“Архаг Д гепатиттай өвчтөнүүдэд тарилгаар хийх Гепалатидын зэрэгцээ бүлэгт, санамсаргүй түүвэрлэлттэй, нууцлалгүй эмнэлзүйн туршилт судалгаа (L47-HD-MN)” олон төвт эмнэлзүйн судалгаа	БНХАУ-ын Shanghai HEP Pharmaceutical Co.,Ltd (428,550,000 төгрөг)	Ч.Мөнхзаяа /ХСҮТ-ийн ЭЦНБМЗТ-ийн эмч/
7.	2025-04-11 сар	Хүний папиллома вирусийн шинжилгээг умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт нэвтрүүлэх туршилт судалгаа	ДЭМБ (146.262.000 төгрөг)	Т.Ундармаа /ХСҮТ-ийн ХХБТЭИА-ны дарга/
8.	2024-2029	Хавдар судлалын үндэсний хоёрдугаар төв	Улсын төсөв, гадаадын зээл, тусламж (\$250'000'000)	Б.Алтанням /ХСҮТ-ийн БМАБА-ны дарга/

Хянасан
Нэгтгэсэн

Ц.Бадамсүрэн /ХСҮТ-ийн НЭМСА-ны дарга/
Д.Алтанзаяа /ХСҮТ-ийн НЭМСА-ны мэргэжилтэн/

Хүснэгт-1

№	Агуулга	Гүйцэтгэл	
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар	“Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үндэсний сүлжээг байгуулах” төсөл	
2	Төсөл, хөтөлбөрийн зорилго	Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үндэсний сүлжээг үндэсний түвшинд бий болгох	
3	Санхүүжилтийн эх үүсвэр	Австрийн Засгийн газар, Монгол улсын Засгийн газар хоорондын хөнгөлөлттэй зээл	
4	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Эрүүл мэндийн яам, Хавдар судлалын үндэсний төв	
		4 жил	
5	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<ol style="list-style-type: none"> 1. “Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үндэсний сүлжээ” төслөөр ХСҮТ-д 12 нэр төрөл, орон нутагт 7 нэр төрлийн нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах 2. Эрт илрүүлгийн үндэсний програм хангамжтай болох 3. Эмч, мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалт зохион байгуулах 	
6	Зардал	Нийт төсөв	10'000'000 евро
		Үүнд:	Төсөв (он)
		Багц №1	2025 он
		Багц №2	Төслийн жагсаалт батлах, Тендерийн хороо байгуулж, тендер зарлах-100%
		Багц №3	Тоног/төх үнийн санал авч, худалдан авалт хийх-0% Сургалтын хөтөлбөр-0%
7	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ.	
	1-р зорилтын хүрээнд:	<ol style="list-style-type: none"> 1. Жагсаалт: ЭМС-ын 2022.09.27 өдрийн А/477 тоот тушаалаар “Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үндэсний сүлжээ” байгуулах төслийн хүрээнд хийгдэх ажлын жагсаалтыг шинэчлэн батлуулсан. 2. Тендерийн үйл ажиллагаа: Барилга байгууламж, тоног төхөөрөмж, програм хангамж хөгжүүлэх, сургалтын чиглэлээр тендерийн бичиг баримтыг боловсруулан, ЭМЯ-нд 2022 оны 06 сард хүргүүлэн, 2022.10.28-нд тендер зарлагдсан. Тендерт ирүүлсэн 1 байгууллагын үнийн санал өндөр байсан тул шалгаруулалтыг үргэлжлүүлэх боломжгүй болсон. Дахин тендер зарлагдаж 2023.11.30 нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулж дууссан. Шалгарсан байгууллагад хуулийн хугацаанд нь сайн дүнтэй шалгарсан тухай мэдэгдэл хүргүүлсэн. 	
	Хүрэх үр дүн:	Төслийн хүрээнд хийгдэх ажлын жагсаалтыг батлуулж, худалдан авах тендерийн үйл ажиллагааг зохион байгуулж, сонгон шалгаруулсан байна.	
	2-р зорилтын хүрээнд:	Хорт хавдар, эрт илрүүлгийн цахим програм хангамжийн хөгжүүлэлт хийгдэнэ	
	Хүрэх үр дүн:	Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	
	3-р зорилтын хүрээнд:	Програм хангамжийн нэмэлт хөгжүүлэлтийн сургалтыг анхан, лавлагаа шатлалын (хавдар бүртгэгч, эс судлаач, эмэгтэйчүүдийн эмч, мэс заслын эмч, өрх сумын эрүүл мэндийн төвийн бүртгэл	

		мэдээллийн ажилтан, статистикч эмч) эрүүл мэндийн байгууллагын эмч мэргэжилтнүүдийг хамруулна				
	Хүрэх үр дүн:	400 орчим эмч мэргэжилтнүүдийг хамруулан хийхээр төлөвлөсөн				
8	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	Монгол улсад хавдрын эрт илрүүлгийн сүлжээг бий болгосноор эрт үедээ илэрсэн хавдрыг хямд зардлаар төгс эмчилж, хянах боломж бүрдэнэ. Ингэснээр хүн амын хавдраас шалтгаалсан хөдөлмөрийн чадвар алдалт болон нас баралт буурна.				
9	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Төслийн хугацаа талдаа орсон боловч ковидын нөхцөл байдлаас шалтгаалан худалдан авах үйл ажиллагааны тендерын явц удаашралтай, 3 удаа зарлагдсан ба 2023.11.30 тендер шалгаруулалт зохион байгуулагдаж дууссан. Шалгарсан байгууллагатай гэрээ байгуулах шатандаа явж байна.				
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлтийн дундаж	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4
		33.3%	100%	0%	0%	-

Хүснэгт - 2.

№	Агуулга	Гүйцэтгэл					
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар	Хавдар судлалын үндэсний төвийн Хорт хавдрын эрт илрүүлэг, дурангийн оношилгоо, эмчилгээний төв					
2	Төсөл, хөтөлбөрийн зорилго	ХСҮТ-д Дурангийн оношилгоо, эмчилгээний төвийг шинээр байгуулах					
3	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын төсөв					
4	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Хэрэгжүүлэгч: Л ХОЁР ХХК					
		2024 оны 06 сарын 07- 2025 оны 11 сарын 26					
5	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<ol style="list-style-type: none"> Барилгын зураг төслийн дагуу барилга угсралт болон дотор заслыг хийж гүйцэтгэх Эмнэлгийн тусламжийн онцгой бүс болох дуран болон мэс заслын өрөө зэрэг хэсгийн дэд бүтцийг шийдэж, ашиглалтад бүрэн оруулах 					
6	Зардал	Нийт төсөв		8 тэрбум 680 сая 168 мянга 680 төгрөг			
		Үүнд:		Төсөв (он)	Гүйцэтгэлийн дундаж хувь 33%		
		Багц №1 1,9 тэрбум		2024 онд 3,7 тэрбум	66%		
		Багц №2		2025 онд 4,5 тэрбум			
		Багц №3		2026 онд 434,5 сая	Гүйцэтгэлийн баталгаа		
7	Төсөл, хөтөлбөрийн зорилт:		Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ.				
	1-р зорилтын хүрээнд:		<ul style="list-style-type: none"> ХСҮТ болон Л ХОЁР ХХК-ийн хооронд 2024.06.07-ны өдөр дугаар №НОННХСҮТ202401015 тоот гэрээг байгуулж, барилгын ажлыг 12 сард эхлүүлсэн. 2025 оны 05 сарын байдлаар барилгын хана, дээвэр, сантехникийн ажлыг оролцуулан, барилга угсралтын ажил 66 хувьтай явагдаж байна. Дээвэр, хучилтыг хийсний дараа дотор заслыг эхлүүлэхээр төлөвлөж байна. 				
	Хүрэх үр дүн:		Барилгын зураг төслийн дагуу барилга угсралт болон дотор заслыг хийж гүйцэтгэх				
	2-р зорилтын хүрээнд:		Одоогоор эхлүүлээгүй байна.				
	Хүрэх үр дүн:		Эмнэлгийн тусламжийн онцгой бүс болох дуран болон мэс заслын өрөө зэрэг хэсгийн дэд бүтцийг шийдэж, ашиглалтад бүрэн оруулах				
8	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)		Цаг агаарын нөхцөл бага зэргийн бэрхшээл учруулсан ч ажлын явц хэвийн үргэлжилж байна. Санхүүжилт удаашралтай байна. (2024 онд 3,7 тэрбум авахаас 1,9 тэрбумыг хүлээн авсан. 2025 оны санхүүжилт төсөвт суугдаагүйтэй холбоотой ажлын явц удааширч, зогсонго байдалд орох магадлалтай)				
9	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ		Төсөл, хөтөлбөрийн хэрэгжүүлэх хугацаа дусаагүй тул хөндлөнгийн үнэлгээ өгөгдөөгүй.				
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)		Биелэлтийн дундаж	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4
			33%	66%	0%	-	-

Хүснэгт - 3.

№	Агуулга	Гүйцэтгэл			
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар	“Бидний түүх-биднийг нэгтгэнэ: хүн төвтэй тусламж үйлчилгээ” хавдраас урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгааны ажлын төсөл			
2	Төсөл, хөтөлбөрийн зорилго	Вакцинаар сэргийлэх боломжтой умайн хүзүүний болон элэгний хорт хавдраас урьдчилан сэргийлэхийн тулд дархлаажуулалтын ач холбогдлын талаар олон нийтийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлж, эрүүл мэндээ хамгаалах зөв ойлголтыг төлөвшүүлэх			
3	Санхүүжилтийн эх үүсвэр	НҮБ-ын Хүүхдийн сан			
4	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Хэрэгжүүлэгч: ХСҮТ-ийн Үйлчлүүлэгчийг дэмжих алба Төслийн удирдагч ба гишүүд: Л.Энхээ /АУ-ны магистр/ ба Нийгмийн ажилтан, Хоол зүйч, Сэтгэл зүйч			
		2025 он 02-р сараас 2025 оны 06-р сар хүртэл			
5	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<ol style="list-style-type: none"> 1. Вакцинаар сэргийлэх боломжтой умайн хүзүүний болон элэгний хорт хавдрын талаар олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх 2. ХПВ-ийн эсрэг дархлаажуулалт болон элэгний В вирусын эсрэг нэмэлт дархлаажуулалтын ач холбогдлыг сурталчлан таниулах 3. Хавдрын эсрэг дархлаажуулалтын талаарх зөв, баттай мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй хүргэх 			
6	Зардал	Нийт төсөв	37 сая 400 мянга		
Үүнд:		Төсөв (он)	Гүйцэтгэл	Хувь	
Багц №1		2025 он	80%		
Багц №2					
Багц №3					
7	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ.			
	1-р зорилтын хүрээнд:	Вакцинаар сэргийлэх боломжтой умайн хүзүүний болон элэгний хорт хавдрын талаар олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх.			
	Хүрэх үр дүн:	ХПВ болон элэгний В вирусын эсрэг дархлаажуулалтын ач холбогдлын талаарх олон нийтийн мэдлэг дархлаажуулалтын талаарх зөв ойлголт, хандлага төлөвшинө.			
	2-р зорилтын хүрээнд:	ХПВ-ийн эсрэг дархлаажуулалт болон элэгний В вирусын эсрэг нэмэлт дархлаажуулалтын ач холбогдлыг сурталчлан таниулах.			
	Хүрэх үр дүн:	Умайн хүзүүний хорт хавдар ба хүний хөхөнцөр вирусийн (ХПВ) эсрэг дархлаажуулалт, элэгний В вирусийн халдвар хэрхэн элэгний хорт хавдар үүсгэдэг талаар тайлбарлаж, В вирусийн эсрэг вакцин нь хорт хавдраас урьдчилан сэргийлэх хамгийн үр дүнтэй арга болох, эрт илрүүлгийн ач холбогдол, шинжилгээний арга, хэн, хэдийд, хаана хандах талаар энгийн ойлгомжтой мэдээллийг өгсөн.			
	3-р зорилтын хүрээнд:	Хавдрын эсрэг дархлаажуулалтын талаарх зөв, баттай мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй хүргэх			
	Хүрэх үр дүн:	Сэтгүүлчийн оролцоотойгоор хавдрын эсрэг дархлаажуулалтын талаарх зөв, баттай мэдээлэл хэвлэл мэдээллийн сувгаар олон нийтэд хүртээмжтэй, ойлгомжтой хэлбэрээр хүрч, иргэдийн мэдлэг, итгэл нэмэгдэнэ.			
8	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Дүгнэлт: Хүн төвтэй тусламж үйлчилгээний ач холбогдлыг олон нийтэд ойлгомжтой, энгийн хэлбэрээр хүргэж чадсан.</p> <p>Ололт, дутагдал, анхаарах асуудлууд: Зарим орон нутагт техник, интернэт дэд бүтэц хангалтгүй байснаас цахим контент хүрэлцээгүй.</p>			

		Иргэдийн хандлагад нөлөөлөх урт хугацааны стратегийг төлөвлөх шаардлагатай.				
9	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжүүлэх хугацаан дусаагүй тул хөндлөнгийн үнэлгээ өгөгдөөгүй.				
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлтийн дундаж	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4
		80%	70%	80%	90%	-

Хүснэгт 4.

№	Агуулга		Гүйцэтгэл	
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар		Умайн хүзүүний хавдрын дотуур эмчилгээний гурван хэмжээст дүрслэлд суурилсан аргын үр дүнг судлах нь АЦХАФ-ын "Умайн хүзүүний хавдар-V" олон төвт эмнэл зүйн судалгаа	
2	Төсөл, хөтөлбөрийн зорилго		Монгол улсад умайн хүзүүний хавдрын дотуур туяа эмчилгээнд Компьютерт томографийн гурван хэмжээст дүрслэлд үндэслэсэн аргыг амжилттай нэвтрүүлэх	
3	Санхүүжилтийн эх үүсвэр		Япон улсын Засгийн газар	
4	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа		ХСҮТ Туяа эмчилгээний тасаг, Цөмийн энергийн комисс 2013 оноос хойш	
5	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд		Азийн 11 орныг хамарсан "Хөхний хавдар-I", "Умайн хүзүүний хавдар-IV", "Умайн хүзүүний хавдар -V" зэрэг олон улсын эмнэл зүйн судалгаанд оролцож, бүртгүүлсэн өвчтөний хяналтыг үргэлжлүүлэн хийх	
6	Зардал	Нийт төсөв		
		Үүнд:	Төсөв (он)	Гүйцэтгэлийн хувь- 98%
		Багц №1	0	Хөхний хавдар-I
		Багц №2	0	Умайн хүзүүний хавдар-III судалгаа
			0	Умайн хүзүүний хавдар-IV судалгаа
		0	Умайн хүзүүний хавдар-V судалгаа	
7	Төсөл, хөтөлбөрийн зорилт:		Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ.	
	1-р зорилтын хүрээнд:		1. Умайн хүзүүний хавдар-III" судалгааны протокол болох умайн хүзүүний хавдрын хими-туяа эмчилгээг зэрэгцүүлэн хавсрах эмчилгээг 2012 оноос ХСҮТ-д эмчилгээний стандарт болгон хэрэглэж байна. 2. "Хөхний хавдар-I" судалгаанд 28 тохиолдол, "Умайн хүзүүний хавдар-IV" судалгаанд 8 тохиолдлыг эмчилсэн. "Умайн хүзүүний хавдар-V" судалгаанд 4 тохиолдлыг протоколын дагуу амжилттай эмчилж, бүртгүүлсэн.	
	Хүрэх үр дүн:		ОУ-ын эмнэлзүйн судалгаанд хамтран оролцох, судалгааны үр дүнг хугацаанд нь хүлээлгэн өгөх, нотолгоонд суурилсан үр дүнтэй туяа эмчилгээний протоколыг хэрэгжүүлсэн байна. Судалгаанд хамрагдсан өвчтөний хяналтыг амжилттай үргэлжлүүлнэ.	
	2-р зорилтын хүрээнд:		АЦХАФ-ын Туяа эмчилгээний төслөөс ирэх 5 жилд шинээр хийхээр төлөвлөж байгаа "Тархины үсэрхийлэлийн хөнгөвчлөх туяа эмчилгээний үр дүн, аюулгүй байдлыг үнэлэх" судалгаанд хамтран оролцох	
	Хүрэх үр дүн:		Шинэ судалгааны протоколыг эх хэл дээр орчуулан, ХСҮТ-ийн Эрдмийн зөвлөлд танилцуулсны дараа ЭМЯ-ны Ёс зүйн хорооноос судалгаанд оролцох зөвшөөрлийг зохих журмын дагуу авч, судалгааг эхлүүлэх	
	3-р зорилтын хүрээнд:		АЦХАФ-2024 чуулга, уулзалтанд Тайланд улсад судалгааны багийн гишүүдээс оролцож, явагдаж буй судалгааны үйл явцыг танилцуулах, бусад мэдээллийг солилцох	

	Хүрэх үр дүн:	Чуулга уулзалтаас гарсан үр дүн, шинэ мэдээлэл, технологийн сургалтыг мэргэжлийн баг хамт олонд зохион байгуулах				
8	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	Олон улсын эмнэлзүйн судалгаанд амжилттай оролцсоноор үр дүнтэй протоколыг туяа эмчилгээнд нэвтрүүлэх, хэрэгжүүлэх боломжтой болно. Бүс нутгийн мэргэжилтнүүдтэй тасралтгүй хамтран ажиллах, туршлага солилцох, харилцааг бэхжүүлэх				
9	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Хангалттай				
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлтийн дундаж	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4
		98,6%	98%	100%	100%	-

Хүснэгт 5.

№	Агуулга		Гүйцэтгэл	
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар		Архаг Д гепатитын эмчилгээнд Гепалатид эмийг хэрэглэх олон төвт, санамсаргүй түүвэрлэлттэй, давхар нууцлалт, плацебо-хяналт бүхий IIa шатны эмнэл зүйн судалгаа (L47-HD-IIa)	
2	Төсөл, хөтөлбөрийн зорилго		Архаг Д гепатитын эмчилгээнд гепалатидын аюулгүй байдал, үр нөлөөг судлах	
3	Санхүүжилтийн эх үүсвэр		БНХАУ-ын Shanghai HEP Pharmaceutical Co.,Ltd	
4	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа		Хэрэгжүүлэгч:	
			<ol style="list-style-type: none"> ХСҮТ ХӨСҮТ Бона Вита БНХАУ-ын Жилиний Их Сургуулийн Нэгдүгээр Эмнэлэг 	
			Судалгааг эхлүүлсэн огноо: 2023 оны 10 сарын 07	
			Судалгааг дуусгасан огноо: 2024 оны 02 сарын 01	
5	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд		<ol style="list-style-type: none"> Архаг Д гепатитын эмчилгээнд гепалатидын аюулгүй байдлыг судлах Архаг Д гепатитын эмчилгээнд гепалатидын үр нөлөөг судлах 	
6	Зардал	Төсөв (нийт зардал)	20'500'000 төгрөг	
		Үүнд:	Төсөв (он)	Гүйцэтгэлийн хувь
	12,000,000	Багц №1	2024	100%
	8,500,000	Багц №2	2024	100%
	Дүгнэлт		<p>Энэхүү судалгааны үед 39 оролцогч илрүүлэг үзлэгт хамрагдсанаас 23 оролцогчийг хамруулан, санамсаргүйгээр бүлэгт хуваарилсан ба судалгааг орхилгүйгээр дуусгасан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> гепалатидын 2.1 мг-ийн бүлэг: 5 оролцогч; гепалатидын 4.2 мг-ийн бүлэг: 6 оролцогч; гепалатидын 6.3 мг-ийн бүлэг: 6 оролцогч; плацебо бүлэг: 6 оролцогч <p>Бүх бүлэгт HDVRNA үзүүлэлт 2-р долоо хоногт суурь үзүүлэлтээс өндөр байсан ба плацебо бүлгийн HDVRNA үзүүлэлт туршилт судалгааны туршид суурь үзүүлэлтээс өндөр хэвээр байв. Гепалатидын тунгийн бүх бүлгүүдэд HDVRNA түвшин 2 дахь долоо хоногоос хойш буурч, хяналтын үе шатны 6 ба 8 дахь долоо хоногт суурь үзүүлэлтээс доогуур хэмжээнд хүрсэн байна. Тухайлбал, 2.1 мг ба 4.2 мг тунгийн бүлгүүдэд HDVRNA буурсан нь ГДВ-т гепалатид дарангуйлах нөлөө үзүүлж байгааг харуулж байна. Энэхүү туршилтыг 4 долоо хоногийн богино хугацааны эмчилгээний горимоор хязгаарласан бөгөөд гепалатидын HDVRNA-д дарангуйлах нөлөө үзүүлэх болон ALT-ийн түвшинг сайжруулах боломжийг судлахын тулд дараагийн эмнэлзүйн туршилтын эмчилгээний хугацааг уртасгах юм.</p> <p>1. Эмчилгээг 2 долоо хоногийн турш зогсоосны дараа гепалатидын эмчилгээний бүлгүүдэд HDVRNA болон ALT-ийн түвшин тогтвортой сайжирсан бол плацебо бүлэгт ийм байдал ажиглагдаагүй нь гепалатидын эмчилгээний үр нөлөө удаан үргэлжилж буйг харуулж байна. Гепалатидын урт</p>	


	<p>хугацааны тасралтгүй эмчилгээ нь HDV RNA-ийг үр дүнтэй дарангуйлж, ALT-ийн түвшинг сайжруулах боломжтой нь харагдаж байна.</p> <ol style="list-style-type: none">2. Судалгаанд хамрагдагсдын HDV RNA түвшний болон гепалатидад үзүүлэх хариу урвалын хэлбэлзэл их, энэхүү туршилт судалгааны түүврийн хэмжээ хязгаарлагдмал зэргээс гепалатидын тунгийн бүлгийн хооронд үр нөлөөний хувьд мэдэгдэхүйц ялгаа илрээгүй. Цаашид энэ талаар илүү судлахын тулд дараагийн эмнэлзүйн туршилтуудад түүврийн хэмжээг нэмэгдүүлж, эмчилгээний хугацааг уртасгах шаардлагатай юм.3. Гепалатидын хувьд аюулгүй байдлын үзүүлэлт нь эерэг байна. Архаг D гепатиттай өвчтөнүүд гепалатидыг сайн тэсвэрлэж байна.4. Гепалатидыг энтекавиртай хамт хэрэглэхэд мэдэгдэхүйц хавсарсан хоруу чанар, сөрөг нөлөө илрээгүй.5. Гепалатидын тунгийн бүлгүүд ба плацебо бүлгийн хооронд аюулгүй байдлын хувьд мэдэгдэхүйц ялгаа ажиглагдаагүй.
--	---

Хүснэгт 6.

№	Агуулга		Гүйцэтгэл		
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар		Архаг D гепатиттай оролцогчдод тарилгаар хийх гепалатидын зэрэгцээ бүлэгт, санамсаргүй түүвэрлэлттэй, нууцлалгүй эмнэлзүйн туршилт судалгаа (L47-HD-MN) Судалгааны шийдвэрүүд: ХСҮТ-ийн Эрдэмийн зөвлөлийн 2024 оны 07 сарын 03-ны өдөр (No 07) Эрүүл мэндийн яамны дэргэдэх Анагаах ухааны ёс зүйн хяналтын хорооноос зөвшөөрөл 2024 оны 07 сарын 09-ны өдөр (No 24/065)		
2	Төсөл, хөтөлбөрийн зорилго		Архаг D гепатитын (ADГ) эмчилгээнд гепалатидын тарилгын (L47) үр нөлөө, аюулгүй байдлыг үнэлэх		
3	Санхүүжилтийн эх үүсвэр		БНХАУ-ын Shanghai HEP Pharmaceutical Co.,Ltd		
4	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа		1. ХСҮТ 2. ХӨСҮТ 3. Бона Вита		
			Судалгааг эхлүүлсэн огноо: 2024 оны 09 сарын 27 Судалгааг дуусгах огноо: 2027 он Судалгааны хяналтын хугацаа: 2029 он хүртэл		
5	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд		Архаг D гепатитын (ADГ) эмчилгээнд гепалатидын тарилгын (L47) үр нөлөө, аюулгүй байдлыг үнэлэх		
6	Зардал	Төсөв (нийт зардал)	428,550,000 төгрөг		
		Үүнд:	Төсөв (он)	Гүйцэтгэлийн хувь	
	23,541,673	Багц №1	2025	100%	
		Багц №2			
	Явцын тайлан		<ol style="list-style-type: none"> Эмнэл зүйн судалгааг эхлүүлсэн: 2024 оны 11 сарын 28-ны өдрөөс 2025 оны 04 сарын 12 хүртэл хугацаанд судалгааны таниулсан зөвшөөрлийг нийт 79 оролцогчоос авч, илрүүлэг үзлэгт хамруулсан. Судалгааны шалгуур хангасан: нийт 38 оролцогчид биохими, ЦДШ, цус бүлэгнэлтийн шинжилгээ, иммунологи, HGS, AFP, ANA, элэгний В болон Дельта вирус ачаалал үзэх шинжилгээ, элэгний С, Е, А вирус ирлүүлэх шинжилгээ, хэвлийн хэт авиан шинжилгээ, хэвлийн тодосгогч бодистой КТГ, зүрхний цахилгаан бичлэг, эмнэл зүйч эмч болон зүрхний эмчийн үзлэгт хамруулан, элэгний эдийн хатгалтын шинжилгээ өгөхийг зөвшөөрсөн 11 оролцогчид тус шинжилгээг хийсэн. Судалгааны бүлгийн хуваарилалт: эмчилгээний 3 бүлэг санамсаргүй хуваарилалт хийж, 2025 оны 01 сарын 10-ны өдөр эмчилгээг эхлүүлсэн. Нийт эмчилгээний бүлэгт 2.1 гр эмийн бүлэгт 15 оролцогч, 4.2 гр эмийн бүлэгт 11, эмчилгээний хойшлуулсан бүлэгт 12 оролцогч байна. Эмнэл зүйн хяналтыг 4 долоо хоног тутамд: <ul style="list-style-type: none"> Судалгааны хувиарт үзлэгээр ЭҮА, ЦДШ, элэгний В болон Дельта вирусийн ачаалал үзэх, ерөнхий биеийн болон амин үзүүлэлт үзэх, тарилгын талбай үнэлэх Эмчилгээний бүлэгт гепалатид тарилга, энтекавир, тарилгын уусмал, тариур, арчдас, аюулгүй хайрцаг өгч байна. 		

	<ul style="list-style-type: none">• Судалгааны эмийг явуулын мөсөн хайрцгаар зөөвөрлөж, оролцогч бүрт олгосон.• Эмчилгээний хойшлуулсан бүлэгт зөвхөн В вирусын энтекавир эм өгч байна. <p>5. Хяналт: Одоогоор 43 хүнийг идэвхтэй хянаж байна.</p> <ul style="list-style-type: none">• 10 оролцогч эмчилгээний 24 долоо хоног,• 27 оролцогч 4 долоо хоног• 6 оролцогч эмчилгээний 8 долоо хоногт <p>6. Эмийн сөрөг нөлөөний талаар: Судалгаанд оролцогч нарт эмтэй холбоотой ноцтой сөрөг нөлөө илрээгүй. Судалгааны 1-0020, санамсаргүй хувиарлалтын R204 дугаартай оролцогч хувийн ажлаар орон нутагт явж байхдаа авто машины осолд орсон. Үндсэн судлаач, эмнэл зүйн судлаач нар 2025 оны 05 сарын 01 өдрийн өглөө мэдсэн бөгөөд дээрх ослын байдлыг 24 цагийн дотор ICH-GCP журмын дагуу ивээн тэтгэгч NEP Pharmaceutical Co.,Ltd яаралтай мэдэгдсэн. Ивээн тэтгэгч болон үндсэн судлаач, эмнэл зүйн судлаачид уг ослын байдлыг судалгааны ноцтой сөрөг нөлөө, эмтэй холбоогүй гэж дүгнэн, эхний ноцтой сөрөг нөлөөний мэдэгдлийг 24 цагийн дотор Эрүүл мэндийн яамны дэргэдэх анагаах ухааны ёс зүйн хяналтын хороонд болон ХСҮТ-ийн Эрдмийн зөвлөлд хүргүүлсэн. Ноцтой сөрөг нөлөөний тухай хоёр дахь мэдэгдлийг 7 хоногийн дотор хүргүүлсэн. Одоогоор оролцогчийн эрүүл мэндийн байдал тогтвортой байгаа тул судалгааны эмийг үргэжлүүлэн хийх талаар төлөвлөж байна.</p> <p>7. ХСҮТ-ийн Эрдмийн зөвлөлд: судалгааны илрүүлэг үзлэгийн тайланг танилцуулах төлөвлөгөөтэй байна.</p>
--	--

Хүснэгт 7.

№	Агуулга	Гүйцэтгэл	
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар	Хүний папиллома вирусийн шинжилгээг умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт нэвтрүүлэх туршилт судалгаа	
2	Төсөл, хөтөлбөрийн зорилго	Хүний папиллома вирус (ХПВ) илрүүлэх шинжилгээг умайн хүзүүний хорт хавдар (УХХХ)-ын эрт илрүүлэгт нэвтрүүлэх туршилт судалгаа (pilot study) хийх	
3	Санхүүжилтийн эх үүсвэр	ДЭМБ	
4	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	ХСҮТ 2025 оны 04 сараас 11 сар хүртэл	
5	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<ul style="list-style-type: none"> Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт амьдарч буй 30, 35, 40, 45 настай нийт 5600 эмэгтэйг ХПВ-ын өндөр хэв шинжийг тодорхойлох шинжилгээнд хамруулах Олон нийт, эмэгтэйчүүдийн дундах умайн хүзүүний хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тухай мэдлэг, хандлагыг сайжруулах нөлөөллийн үйл ажиллагааг хийх ХПВ-т суурилсан умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн талаар эмч мэргэжилтнүүдийн мэдлэг хандлагыг дээшлүүлэх, чадавхижуулах 	
6	Зардал	Нийт төсөв	146.262.000
		Үүнд:	
		Багц №1	Хэлэлцүүлэг, сургалтын зардал
		Багц №2	Мэдээлэл цуглуулах, шинжилгээ хийх зардал
		Багц №3	Туршилт судалгааны боловсруулалт, дүн шинжилгээ, тайлан бичих
7	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ.	
	1-р зорилтын хүрээнд:	30, 35, 40, 45 настай нийт 5600 эмэгтэйг эмэгтэйчүүдийг хүний папиллома вирусын өндөр хэв шинжийг тодорхойлох шинжилгээнд хамруулах	
	Хүрэх үр дүн:	ХУД-ийн 25 хорооноос 2025.06.12 -ны байдлаар 2400 гаруй эмэгтэйгээс ХПВ-ын өндөр 14 хэв шинж тодорхойлох case HPV шинжилгээг хийгээд байгаа бөгөөд 2025.08.01-ний дотор 5000 эмэгтэй хамруулсан байна.	
	2-р зорилтын хүрээнд:	Эмэгтэйчүүдийн дундах умайн хүзүүний хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тухай мэдлэг, хандлагыг сайжруулах нөлөөллийн үйл ажиллагааг хийх	
	Хүрэх үр дүн:	 <p>ХУД-ийн 25 хороонд ХПВ тухай агуулга бүхий плакат, нугалбарыг боловсруулан, 12000 ширхэгийг хэвлүүлэн тараасан.</p>	

	3-р зорилтын хүрээнд:	Хүний папиллома вирус суурилсан умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн талаар эмч мэргэжилтнүүдийг мэдлэг хандлагыг дээшлүүлэх, чадавхижуулах				
	Хүрэх үр дүн:	2025.05.01 ХУД-ын 25 өрхийн эмнэлэг ХПВ шинжилгээ авах сувилалч, их эмч, мэргэжилтэнийг хамруулсан 80 хүний сургалтыг хийсэн.				
8	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<ul style="list-style-type: none"> Шинжилгээнд хамрагдсан эмэгтэйчүүдийн УХХХ сэргийлэх мэдлэг хандлага сайжирч байна. Эмэгтэйчүүдийн УХХХ эрт илрүүлэгт хамрагдах идэвхи харьцангуй дээшилсэн. УХХХ эрт илрүүлгийн эмч мэргэжилтний мэдлэг хандлага сайжирсан. 				
9	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ					
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлтийн дундаж	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4
		50	30	70	100	

Хүснэгт 8.

№	Агуулга	Гүйцэтгэл	
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар	“Хавдар судлалын үндэсний хоёрдугаар төв” төсөл	
2	Төсөл, хөтөлбөрийн зорилго	Олон улсын жишигт нийцсэн хавдрын тусламж үйлчилгээг хүн амд хүргэх	
3	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын төсөв болон буцалтгүй тусламж, зээл	
4	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Монгол улсын Засгийн газар, Эрүүл мэндийн яам, Хавдар судлалын үндэсний төв 2025-2029 он хэрэгжих хугацаа 4 жил	
5	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<ol style="list-style-type: none"> 1. Төв байгуулах ажлын зураг төсөл, техникийн нөхцөл болон бусад шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэх, батлуулах 2. Барилгын ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэхэд хяналт тавих 3. Төвийн дотоод цахилгаан, дулаан, цэвэр, бохир усан хангамж болон агаар сэлгэлтийн системийг шийдвэрлэх, төвийн гаднах цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт 	
6	Зардал	Нийт төсөв	250'000 доллар
		Үүнд: Багц №1	Төсөв (он) 2025 он
		Багц №2	
		Багц №3	
7	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ.	
	1-р зорилтын хүрээнд:	<p>МУ-ын Ерөнхийлөгчийн ивээл дор ажлын хэсгийг байгуулан, төслийн ажлыг эхлүүлээд байна.</p> <p>2024 оны 10 сард: БЗД-ийн 11-р хороо Чулуутын аманд шинээр баригдах “Хавдар судлалын үндэсний хоёрдугаар төв”-ийн дараах техникийн нөхцөлийг гаргуулж авсан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Цахилгааны техникийн нөхцөлийг авахаар Эрчим хүчний яаманд шаардлагатай материалыг хүргүүлсэн. 2. Цэвэр, бохирын усан хангамжийн техникийн нөхцөлийг Ус сувгийн удирдах газрын 2023.05.25-ны өдрийн дугаар № 284/23 тоот техникийн нөхцөлийг 2024.11.11-ний өдөр авсан. 3. Төвийн дулаан хангамжтай холбоотой асуудлаар Дулааны шугам сүлжээ ТӨҮГ-аас 2024.10.17 өдрийн дугаар 01/2388 тоот албан бичигт төслийн байршилд төвлөрсөн дулаан хангамжийн шугам сүлжээ байхгүй бөгөөд хэт алслагдсан байршил тул дулаанаар хангах техникийн боломжгүй хариу ирсэн. <p>2024 оны 11-12 сард:</p> <ol style="list-style-type: none"> 4. Төслийн хүрээнд СХД-ийн 34-р хороо, Баянголын аманд Хавдар судлалын хоёрдугаар төвийг байгуулах 150'000м² талбай бүхий газрын зөвшөөрлийг Нийслэлийн Засаг даргын 2025.01.03-ны өдрийн дугаар № А/02 захирамжаар авсан. 5. Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанд хүсэлт гаргаж, түр хашаа барих зөвшөөрлийг авсан. 	

6. Төслийн **Архитектур төлөвлөлтийн даалгаврыг** Нийслэлийн Ерөнхий Архитекторын 2025.01.13-ны өдрийн дугаар: 2025/00-038 зөвшөөрөл авсан.
7. Ажлын зураг, төсөв боловсруулах шатандаа явж байгаа ба 2025.06.30-нд хүлээн авахаар төлөвлөсөн. Нийслэл болон СХД-ийн ЗДТГ-тай хамтран төвийн гаднах 3 га талбайд хийгдэх цэцэрлэгт хүрээлэнгийн хашаа, зураг төслийн ажил явагдаж байна.

2025 оны 01-04 сард:

1. ХСҮТ-ийн алба, тасгийн дарга, эрхлэгч болон инженер техникийн мэргэжилтнүүдтэй хамтарч, барилгын ажлын эскиз зурагт тусгагдсан шинэ төвийн давхарууд болон бүх тасаг нэгжийн өрөөний зохион байгуулалтанд тулгалт хийж, хавдрын тусламж үйлчилгээний онцлогтой уялдан, зохион байгуулалтын өөрчлөлт оруулах асуудлыг нягтлан ажиллалаа. Энэ асуудлаар ЭМЯ, ХСҮТ, Барилгын хөгжлийн төв, Бодь пропертийз ХХК-ийн төлөөлөлтэй хамтарсан уулзалт зохион байгуулж, **зохион байгуулалтын өөрчлөлт** оруулах талаар харилцан зөвшилцөлд хүрсэн.
2. БЗД-ийн 11-р хорооны Чулуутын аманд байгуулах шинэ төвийн 10 га газрын **“Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ судалгааны дүгнэлт”** гаргуулах талаар шаардлагатай материалыг бүрдүүлж, дүүргийн Засаг даргын тодорхойлолтыг гаргуулж авсан.
3. Монгазар ХХК хийгдэж байгаа Чулуутын амны 10 га газарт **“Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт”**-ийг гаргуулахаар Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яаманд шаардлагатай материалыг бүрдүүлж өгсний дагуу дүгнэлт шийдвэр гарсан.
4. **Цэвэр, бохирын усан хангамжийн техникийн нөхцөлийг** Ус сувгийн удирдах газрын 2025.03.27-ны өдрийн №118/25 тоот техникийн нөхцөл авсан.
5. Бодь пропертийз ХХК-аас албан бичгүүдийн хариу явуулсан. Шинэ төвийн **зураг төслийн нэмэлт даалгавар болох циклотроны үйлдвэрийг** тусгаж оруулсан.
6. Төвийн танилцуулга болон ажлын хэсгийн хийсэн ажлын тайланг бэлтгэж өгсөн.
7. **Цахилгаан эрчим хүчээр хангах техникийн нөхцөлийг** Эрчим хүчний яамны 2025.04.01-ний өдрийн №51/2025 тоот техникийн нөхцөл авсан.

2025-05-06 сард:

8. Төвийн **дулааны техникийн нөхцөл** Эрчим хүчний яамны 2025.05.25-ны өдрийн дугаар ДЦС-4-1/2025 тоот техник нөхцөл авсан.
9. Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газраас Баянголийн аманд Ус, дулаан дамжуулах 3 дугаар төвд залгагдах ачаалал халаалт 5.63-гкал/цаг, ХХУС-4.38 гкал/цаг хүчин чадалтай байхаар техникийн тодруулга 2025.05.01-ний өдрийн Дугаар: №2025/29 албан тоотыг авч, Эрчим Хүчний яаманд хүргүүлсэн бөгөөд шаардлагатай нэмэлт материалыг бүрдүүлж өгсөн. Үүний дагуу ТЭЦ-4 станцаас **нэмэлт тодруулгыг** авч, Эрчим хүчний яаманд хүргүүлсэн. Техникийн нөхцөлийг цаг хугацаанд гаргуулан авч, зураг төсөл хийж буй Бодь пропертийз ХХК-д хүргүүлсэн.

		<p>10. Төвийн холбооны техникийн нөхцөлийг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ны 2025 оны 05-р сарын 20 өдрийн Дугаар: В-U2025/345 тоот техникийн нөхцөл авсан.</p> <p>11. ЭМЯ, ХСҮТ, Бодь пропертийз ХХК хамтарсан ажлын хэсгийн уулзалт зохион байгуулж, тухай бүр асуудлыг шийдвэрлэж байна.</p> <p>12. БЗД-ийн 11-р хороо, Чулуутийн аманд байршилтай шинэ төвийн 10га газарт хяналтын таван цэг тавьсан.</p> <p>13. Бодь пропертийз ХХК-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу төвийн цахилгааны техникийн нөхцөлд нэмэлтээр трасст хөндлөн огтолсон 10 кВ-ын кабель шугамуудыг шилжүүлэн зөөх техник нөхцөлийг УБЦТС-д хүсэлт илгээсэн.</p> <p>14. Бодь пропертийз ХХК-аас Дулааны техникийн нөхцөлөөс нэмэлтээр тодруулга авах шаардлагатай гэсэн хүсэлтийн дагуу Эрчим хүчний яам болон ТЭЦ-4 станцийн холбогдох газарт хандаж холбож өгсөн.</p>				
	Хүрэх үр дүн:	“Хавдар судлалын үндэсний хоёрдугаар төв”-ийн ажлын зураг төсөл, техникийн нөхцлүүд болон бусад шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлж, холбогдох газраар баталгаажуулсан байна.				
	2-р зорилтын хүрээнд:					
	Хүрэх үр дүн:	Барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, мэргэжлийн хяналтын холбогдох байгууллагуудын зөвшөөрлийг хугацаанд нь гаргуулж ажилласан байна.				
	3-р зорилтын хүрээнд:					
	Хүрэх үр дүн:	Төвийн цахилгаан, дулаан, цэвэр, бохир усан хангамж болон агаар сэлгэлтийн системийн хэвийн үйл ажиллагааг хангаж, төвийн гаднах цэцэрлэгт хүрээлэнг тохижуулсан байна.				
8	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	Одоогоор үйл ажиллагаа төлөвлөсөн хугацаанд явагдаж байна.				
9	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Хэрэгжилтийг үнэлэх хугацаа болоогүй.				
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлтийн дундаж	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4
		31,7%	95%	0%	0%	

Хянасан:

Б.Алтанням /ХСҮТ-ийн БАБМА-ны дарга/

Тайлан гаргасан:

Н.Хүрэллхам /Төслийн менежер/

Эх сурвалжийн дэлгэрэнгүй мэдээлэл:

Алба: НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД, СУРГАЛТЫН АЛБА

Албан тушаал: Мэргэжилтэн Д.Алтанзаяа

Утас: 11-450043

Цахим шуудан: altanzaya@cancer-center.gov.mn